

*Б.Амандых-ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын
академийн 8062-р дамжааны суралцагч.*

ахлах дэслэгч

***Ц.Бямбарагчаа - ХСИС-ийн Хууль сахиулахын
удирдлагын академийн Онцгой байдлын удирдлага,
стратегийн профессорын багийн профессор.
доктор (PhD), хурандаа***

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХАД ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙГ ХАНГАХ АСУУДАЛД ХИЙСЭН ОНОЛЫН ШИНЖИЛГЭЭ

Хураангуй: Энэхүү илтгэлээр гамшгийн эрсдэлийг бууруулахад төр, хувийн хэвшлийн түншлэлийг онолын хүрээнд судлахыг зорьсон болно.

Түлхүүр үг: Төр, хувийн хэвшил, түншлэл

Удиртгал

Гамшгийн эрсдэлийг бууруулах нь маш нарийн зохицуулалт бүхий хөгжлийн хандлагатай олон талт асуудал бөгөөд түүнийг дан ганц гамшгаас хамгаалах салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлэх боломжгүй гэдгийг дэлхий нийт хүлээн зөвшөөрч үүнийг бүх талын оролцоо, түншлэлийн замаар хэрэгжүүлэхийг чухалчилж байна.

Монгол Улсын төр, засаг Гамшгаас хамгаалах тухай хуулийг 2003 онд батлан хэрэгжүүлж эхэлснээс хойших харьцангуй богино хугацаанд авсан арга хэмжээнүүдийн үр дүнд бодлогын болон үйл ажиллагааны хүрээнд шинэчлэлт тасралтгүй өрнөж, гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоо төлөвшиж, олон ажлыг хийж хэрэгжүүлж байгаа ч гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хуулинд заасан шаардлагаар жигд зохион байгуулж, иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэг, хандлагыг сайжруулах, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын бэлэн байдлыг дээшлүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулахад төр, хувийн хэвшлийн түншлэлийг нэмэгдүүлэх зэрэг чиглэлд нэлээдгүй зүйлийг хийх шаардлага Түлгарч байна.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангах асуудал Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогын үндсэн чиглэлд "Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоог бэхжүүлж, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төв, орон нутгийн төрийн болон мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн

оролцоог хангана” гэсэн бол “Тамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр”-г “Төв, орон нутгийн төрийн болон мэргэжлийн байгууллага, хувийн хэвшлийн гамшгаас хамгаалах арга хэмжээнд оролцох оролцоог нэмэгдүүлж, түншлэл, хамтын ажиллагаа, салбар дундын удирдлага, зохицуулалтыг боловсронгуй болгох” гэж тус тус заасан байна.

Өнөөдөр гамшгаас хамгаалах салбарт түншлэлийн төрийн байгууллага хоорондын түншлэлийн хэлбэр болох Улсын Онцгой комисс ба Гамшгаас хамгаалах албад гэсэн хэлбэр, төрийн болон олон улсын байгууллага хоорондын түншлэл болох МУЗН, Дэлхийн зөн Монгол зэрэг байгууллагатай тогтоосон түншлэл бий болж гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж байгаа боловч төрийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай түншилсэн хэлбэр одоогоор тодорхой бус байна.

Нэг. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа

Гамшиг. **Гамшиг** буюу *disaster* гэдэг үг нь латин хэлний *dis* (муу) ба *astro* (од) буюу “муу- од” өөрөөр одон орон, зүрхайн золгүй нөхцөл гэсэн утга санаанаас үүсэлтэй.

Гамшиг (**disaster**) гэдгийг Вэбстерийн толь бичигт "их хэмжээний хохирол, гарз, сүйрлийг авчрах гэнэтийн аюултай үзэгдэл, Википедиа тайлбар тольд байгалийн болон хүний үйл ажиллагаатай холбоотой аюулын улмаас их хэмжээний хохирол. сүйрэл учрах, хүний амь нас үрэгдэх болон хүрээлэн буй орчинд эрс өөрчлөлт орох нөхцөл үүсэхийг"^{1 2 3} хэлнэ гэсэн бол Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд гамшиг гэдгийг “ган, зуд, үер ус, өвчин тахал, дайсны хөнөөл зэрэг аюул” хэмээн тайлбарласан байна.

Гамшгийг улсын болон хувийн хэвшлийн байгууллагууд, эрдэмтэн, судлаачид өргөн хүрээтэйгээр тал бүрээс нь судалж өөрсдийн үзэл бодлын үүднээс өөр хоорондоо илт зөрүүтэй биш олон янзын тодорхойлолт гаргасан байдаг бөгөөд эдгээр тодорхойлолтыг нэгтгэн дүгнэж үзвэл гамшиг нь аюул, ослоос учирсан хохирол ба түүнд нэрвэгдэгсдийн хор уршгийг арилгахад тухайн нийгмийн чадавхаас хэтэрсэн /тухайн газар орны чадавх хүрэхгүй болсон нөхцөл/ үзэгдэл тохиолдох гэсэн утгаар гол төлөв тодорхойлогдож байна’.

Харин Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуульд “**гамшиг**” гэж аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн

¹ a sudden calamitous event bringing great damage, loss, or destruction

² A disaster is a natural and man-made hazard that has come to fruition, resulting in an event of substantial extent causing significant physical damage or destruction, loss of life, or drastic change to the environment.

³ Quarantelli, 1984; Perry, 1991; Tierney, Lindell & Perry, 2001 ,p.43

байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг¹ хэлнэ гэжээ.

Гамшиг нь шинжлэх ухааны аль салбарт хэрэглэгдэж байгаа болон хэрэглэгчийн зорилгоос хамаараад түүний утга, агуулга нь янз бүрээр ойлгогдож иржээ.

Төр-хувийн хэвшлийн түншлэл гэж нөөц, ур чадвар, боломжийг хуваалцан нийтлэг зорилтыг шийдвэрлэхийн тулд Засгийн газрын, бизнесийн, мэргэжлийн болон эсвэл шинжлэх ухааны байгууллагуудын, эсвэл иргэний нийгмийн бусад элементүүдээс оролцуулсан төрийн болон төрийн бус байгууллагуудын сайн дурын холбоо эсвэл байгууллага юм. Түншлэлд ерөнхийдөө бие даасан үйл ажиллагааны боломжоос тэдний холбогдох чанаруудыг нэгтгэх нь илүү боломж өгнө гэдгийг хүлээн зөвшөөрч, хамтарсан шийдвэр гаргаж, үүрэг, хариуцлага, боломж, эрсдэлийг хуваалцах зарим хэлбэрүүд орно.

Хоёр. Төр, хувийн хэвшлийн түншлэл.

Дэлхийн олон улс гүрнүүд, тэр дундаа "шилжилтийн" гэгдэх тодотголтой хуучин социалист орнууд болон зах зээл, ардчиллын замаар замнаж буй хэдий ч эдийн засаг нийгмийн хөгжлөөр буурай эсвэл сул дорой хэвээр байгаа “хөгжиж буй” орнуудад иргэдэд шаардлагатай нийтлэг үйлчилгээг үзүүлэх асуудал нэлээд хүндрэл бэрхшээлтэй тулгарч байна. Ялангуяа хатуу, зөөлөн дэд бүтэц, түүний дотор зам гүүр, эрчим хүч, орон сууц, нийтийн үйлчилгээ, хоол хүнс, ундны усны хангамж, эрүүл мэнд, соёл, боловсрол, байгаль орчин, нийгмийн халамж үйлчилгээний салбарт гачигдал доголдол, гамшиг хямрал тохиолдох нь нийтлэг үзэгдэл болжээ.

Инженерийн төлөвлөлтгүй хот байгуулалт, эрчим хүчний саатал тасалдал, авто замын түгжрэл, хоцрогдсон нийтийн тээвэр, эвдэрч сүйдсэн зам талбай, нийтийн эзэмшлийн ногоон байгууламж цэцэрлэг, хуучирч муудсан сургууль, эмнэлэг, стандартын шаардлага хангахгүй цэвэр бохир усны шугам хоолой, яаралтай засвар арчилгаа хэрэгтэй болсон дэд бүтцийн барилга байгууламж гээд энэ талаар эцэс төгсгөлгүй жишээг дурдаж болно. Эдгээр асуудал нь эргээд нийгэмд хөгжил бүтээмжийг сааруулж улс үндэстний өрсөлдөх чадварыг бууруулж хөгжлийг чөдөрлөн саатуулах гол шалтгаан болдог.

Хэмжээ дамжаа, хийж хэрэгжүүлэх чадамж, боломжийн хувьд өөр өөр боловч дэлхийн их бага бараг бүх оронд нийтлэг шинжтэй гэж хэлж болохоор эдгээр бэрхшээлийг даван туулах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар сүүлийн жилүүдэд багагүй ажил, эрэл хайгуул хийгдэв. Судалгаа шинжилгээ.

¹ Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль. 4.1.1. УБ.,2015

эрэл хайгуулын эдгээр ажлын дүнд хэд хэдэн ерөнхий дүгнэлт гарчээ. Энэ бол

Нэгдүгээрт. Хийж чадах. өөрөө дотооддоо зохицуулж болох бүхнийг хувийн хэвшил. зах зээлийн механизмд үлдээх буюу шилжүүлэх.

Хоёрдугаарт. Дан ганц хувийн хэвшил. хувийн санаачлагын дүнд шийдвэрлэх боломжгүй боловч төр зайлшгүй оролцох албагүй хяналт, бодлого, зохицуулалтын шинжтэй бүх асуудлыг бүлэг аж ахуйн нэгж, салбарын хувийн хэвшлийн хамтын нийгэмлэг. мэргэжлийн эвсэл. холбоодод хариуцуулан тэдгээрийг дэмжиж ажиллах.

Гуравдугаарт: Төрд зөвхөн түүний онцгой бүрэн эрхэнд холбогдох чиг үүргийг үлдээж бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулахад иргэд, хувийн хэвшил, ТББ-ыг өргөн оролцуулж төр засгийн байгууллагын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг ханган хүнд суртал чирэгдлийг багасгах зэрэг юм.

Эдгээр зөвхөн онолын хувьд төдийгүй, амьдрал практик дээр ч аль эрт шалгагдаж батлагдсан зүйл юм. Харамсалтай нь бодит байдал болгон хэрэгжүүлэх тал дээр улс орон бүрийн хөгжлийн түвшин, үндэсний соёл уламжлал, засаглалын төрх хэлбэрээс хамаарч өөр өөр, хуримтлагдсан туршлага ч газар бүр харилцан адилгүй байгаа нь ойлгомжтой.

Дэлхий нийтэд PPP (Public Private Partnership) хэмээх гуравхан үсгээр товчлогдон хэрэглэгдэх болсон Төр, хувийн хэвшлийн түншлэлийн санаачилгын гол утга агуулга нь чухамдаа төрөөс нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа хувийн хэвшил болон төрийн бус байгууллагаар дамжуулан хэрэглэхэд байдаг. Төр хувийн хэвшилтэй хөрөнгө санхүү, ур чадвараа нэгтгэнээр эрсдэл болон үр дүнгээ хуваалцаж бэрхшээл сорилтыг гарз хохирол багатай даван туулах шинэ гарц бий боллоо.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн олон хэлбэрүүд байж болно.Үүнд:

Төр, хувийн хэвшлийн түншлэл /PPP- Public Private Partnership/

Нийгмийн болон дэд бүтцийн салбарын үйлчилгээг шаардлагатай мэдлэг чадвар, хөрөнгө оруулалт, техник технологи ашиглан хувийн хэвшлээр гүйцэтгүүлж, учирч болзошгүй санхүүгийн. технологийн, үйл ажиллагааны гэх мэт эрсдэлийг хоёр тал гэрээнд заасан нөхцөлийн дагуу хүлээхийг хэлнэ.

Төр, хувийн хэвшлийн хэлэлцэл /PPD-Public Private Dialogue/

Төрийн зүгээс хөгжлийн бодлого боловсруулах үйл явцад хувийн хэвшлийг оролцуулах, тэдний санаа бодлыг оролцооны аргад тулгуурлан тусгахад чиглэгдсэн арга хэрэгсэл юм.

Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх хэлбэр /Outsourcing/

Төрийн бус байгууллагууд болон ашгийн бус байгууллагууд зарим

төрлийн хяналт хийж, эрх олгох, нийгмийн суурь үйлчилгээ үзүүлж, стандарт бий болгож нэвтрүүлэх боломжтой болсон гэж ойлгож болно.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлсэн туршлага, судалгаанаас үзэхэд энэхүү үйл ажиллагаа нь засгийн газарт нэлээд олон талын ашиг тусыг авчирдаг байна. Тодруулбал, төсвийн хязгаарлалтын улмаас томоохон төслийг бүрэлдэхүүн хэсгээр задлан авч үзэхийн оронд асуудлыг бүтээлч болон шинэлэг байдлаар шийдэх, төсөл хэрэгжих зардал болон цаг хугацааг бууруулах, эрсдэлийг шилжүүлэх илүү туршлагатай томоохон худалдан авагчийг татан оролцуулах, шинэ технологи нэвтрүүлэх зэрэг юм.

Бүхэлдээ төр, хувийн хэвшлийн түншлэлийг нэвтрүүлснээр төсвийн зардлыг багасгах боломж нээгдэнэ. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэхэд анхаарах хэд хэдэн зүйл бий. Хамгийн **эхний асуудал** бол хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх явдал юм. Үүний тулд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль гаргах эсвэл холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах замаар шийдэж болно.

Хэрэгжилтэд тулгарах **хоёр дахь** бэрхшээл нь санхүүжилтийн асуудал юм. Төсөл нь нэн өндөр эрсдэлтэй байдаг тул эдийн засгийн хувьд үүнийг даван туулахад хүндрэлтэй байдаг. Тиймээс олон улсын санхүүгийн байгууллага болон зарим нэг тусгай нөхцөлийн тусламж, дэмжлэг шаардлагатай болдог.

Төр, хувийн хэвшлийн түншлэл нь тодорхой ашиг тус авчрахаас гадна зарим нэг хүндрэлтэй асуудал үүсгэдэг болохыг ч анхаарахгүй байж болохгүй. Жишээ нь: төрөөс шаардлагатай судалгаа шинжилгээ хийлгүйгээр хувийн хэвшилд хөрөнгийн эргэлтийг хэт хурдан шилжүүлснээр иргэд, олон нийтэд үзүүлэх чухал үйлчилгээний нийлүүлэлтэд аюул учрах эрсдэлтэй. Иймээс хэдийгээр ямар нэгэн багц томъёолол эсвэл бүрэн төгс баталгаат арга барил байхгүй ч төр, хувийн хэвшлийн түншлэлийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд дараах зүйлд анхаарах хэрэгтэй болохыг судлаачид зөвлөдөг¹.

“Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого”-ыг УИХ-аас **2009** онд баталсан.

Монгол Улсын Засгийн газрын **2011** оны **36** дугаар тогтоолоор батлагдсан хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих үндэсний стратегийн үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.6 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нь” сэдэвт бүсийн форумыг семинарыг **2011** оны **6** сард зохион байгуулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын **2016-2020** оны үйл ажиллагааны хөтөлбөрт гамшгаас сэргийлэх, хор нөлөөг арилгах үндэсний чадавхи бэхжүүлэх бодлогын хүрээнд “Тамшгаас хамгаалах эрх зүйн орчин.

¹ Цэрэндорж Д, Дэлхийн менежмент, хамаарахуйн монгол ухаан,УБ.,2012,х330

менежментийн тогтолцоог боловсронгуй болгож, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, эртнээс сэрэмжлүүлэх үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулж, бүх нийтийн оролцоог сайжруулан, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлнэ”¹ гэж заасан билээ.

Гамшгийн эрсдэлийг бууруулах түншлэл хамтын ажиллагаа ямар учраас хэрэгтэй вэ?

- Иргэд, олон нийтийн хамтлаг хөдөлгөөнийг дэмжих
- Орон нутагт төрийн байгууллагыг дэмжих
- Гамшигтай тэмцэх байгууллагуудын нөөц бололцооны хомсдол багасах
- Орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн үйл ажиллагааг дэмжих
- Адил чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй байгууллага хоорондын харилцаа сул мөн үйл ажиллагааны давхардал
- Өнөөгийн гамшгаас үүдэх хохирлын хэмжээ, төрөл зүйл
- Олон улсын чиг хандлага

Гамшгийн эрсдэлийг бууруулах түншлэл хамтын ажиллагааны шинэжүүд

- Орон нутгийн иргэд олон нийтийн үүсгэл санаачилга оролцоог шингээсэн
- Орон нутгийн төр, иргэдийн хоёр талын оролцоогоор төлөвлөгдөж хэрэгждэг
- Олон талт хамтын ажиллагаа
- Оролцогч бүрийн эрэлт хэрэгцээг хангасан
- Оролцогчид нь үйл ажиллагааны өртөг зардлаа хувааж гаргадаг

Түншлэлийн засаглал. Түншлэл нь улсын салбарт тулгамдаж буй асуудал, тавигдсан зорилтыг шийдвэрлэхэд чиглэгдээд зогсохгүй сайн засаглалыг төлөвшүүлэх зарчмыг тулгуур болох учиртай. Засаглалыг Дэлхийн банк "Улс орны тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэгч нь дан ганц төр биш учраас уламжлалт хэлбэрээс илүүтэйгээр бодлогод оролцогч талуудын оролцоонд түшиглэсэн нийгмийн удирдлагад шилжих үйл явц хэмээн тодорхойлжээ.²

Зарим судлаач (тухайлбал, Liuffer, 1999) асуудалд түншлэлийн үүднээс хандах үед тулгарч буй том асуудал бол түншлэл бүтэц, үйл явцыг задлан, ингэснээр хариуцлага, тайлагналыг тодорхой бус болгож байна гэж үзэж байна.

¹ Монгол Улсын Их Хурлын 45 дугаар тогтоол.4.3.3. УБ..2016

²World Bank. From Government to Governance: Moving into the 21st century, World Bank Issue paper.p.5

Түншлэгч тал “бизнесийн нууц”, “мэдээллийн аюулгүй байдал” гэх шалтгаанаар оролцогч талуудад мэдээлэл өгөхөөс татгалзсан нөхцөлд засаглал, хариуцлагын тогтолцоотой холбоотой асуудал хурцаар тавигддаг байна. (Roberts. 2002).

Түншлэл, ялангуяа төр, хувийн салбарын түншлэлийн тулгамдсан асуудал бол нийтийн хөрөнгө мөнгийг захиран зарцуулж байдаг байгууллагын хувьд түншлэлийн засаглал нь хир тохиромжтой вэ гэдэгт оршиж байна. Засаглалын суурь зарчмыг хадгалах замаар янз бүрийн хамтын хүчин чармайлтыг нэгтгэж чадах эсэх нь түншлэлийн үндсэн сорилт болж байна.¹

Гамшгаас хамгаалах менежментийн дүр төрх өнөө үед төр олон нийтийн хамтын ажиллагаанд түшиглэсэн гамшгийн эрсдэлийг бууруулах менежментээр тодорхойлогдож байна. Гамшгийн эрсдэлийг бууруулах нь маш нарийн зохицуулалт бүхий хөгжлийн хандлагатай олон талт асуудал бөгөөд түүнийг дан ганц гамшгаас хамгаалах салбарт үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлэх боломжгүй гэдгийг дэлхий нийт хүлээн зөвшөөрч НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөл болон Ерөнхий ассемблейгаас улс орнуудыг гамшгийн эрсдэл бууруулах үндэсний механизмтай болохыг зөвлөж байгаа юм. Энэ зөвлөмжийн дагуу Хёогогийн үйл ажиллагааны хүрээ баримт бичигт үндэсний болон орон нутгийн түвшинд тодорхой үүрэг, хариуцлага бүхий Үндэсний платформ байгуулахыг уриалсан байна.

Орчин үед гамшгаас хамгаалах менежментийн үзэл баримтлал нь Төр, олон нийтийн хамтын ажиллагаанд тулгуурлах замаар гамшгийн эрсдэлийг бууруулах боломжтой гэж үзэхийн зэрэгцээ төрийн байгууллага бүтээмжээ сайжруулахад хэрэглэгчдээр удирдуулан тэдгээрийн хүсэлт, шаардлагыг баримжаалсан үйл ажиллагаа явуулах үзэл санаа гамшгаас хамгаалах менежментийн үзэл баримтлалд онцгой ач холбогдолтой асуудал болж байна. Учир нь гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд гамшгийн хохирлыг хамгийн ихээр амсдаг орон нутгийн иргэдийг оролцуулдаггүй байснаас нэн чухал шаардлагатай хүмүүнлэгийн тусламж эзнээ олохгүй байх, гадны шаардлагагүй нөөцийг ихээр төвлөрүүлэх, цаашилбал, гамшгийн эрсдэл, эмзэг, өртөмтгий байдлыг бууруулж чадахгүй байх зэрэг дутагдлууд гардаг.

Энэхүү дутагдлыг арилгах арга зам бол гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг иргэдийн оролцоо, түншлэл хамтын ажиллагаанд тулгуурлан явуулахад чиглэсэн Олон нийтэд түшиглэсэн гамшгийн эрсдэлийг бууруулах менежмент /Community Based Disaster Risk Reduction Managenient/-nfir бий

¹ Тони Бовэйрд, Элке Лейффлер. Улсын салбарын менежмент, засаглал.УБ..2014,х.211
Сэржмядаг Д. Байгалийн гамшгийн менежмент, түүнийг боловсронгуй болгох нь,
Гамшгийн менежмент эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл,УБ.,2009,х.80

болгох үзэл санаа юм. "Олон нийтэд түшиглэсэн гамшгийн эрсдэлийг бууруулах менежмент гэж аюулд хамгийн их өртөх магадлалтай хүмүүсийг гамшгаас хамгаалах менежментийн шийдвэр гаргах төлөвлөлт болон хэрэгжүүлэх үйл ажиллагааны бүх түвшинд оролцуулах үзэл санааг хэлнэ" гэж НҮБ-ын Гамшгийг бууруулах олон улсын стратегийн газраас тодорхойлсон^{1 2}. Олон нийтэд түшиглэсэн гамшгийн эрсдэлийг бууруулах менежментийг хэрэгжүүлэх нь нэг талаас гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэдийн оролцоо хангагдахаас гадна тус үйл ажиллагааг хэрэглэгчийн хүсэл, шаардлагад нийцүүлэн явуулах боломж бүрдэх юм,

Дүгнэлт

Гамшиг нь шинжлэх ухааны аль салбарт хэрэглэгдэж байгаа болон хэрэглэгчийн зорилгоос хамаараад түүний утга, агуулга нь янз бүрээр ойлгогдон ирсэн байна.

Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, эрдэмтэн, судлаачид гамшгийг өргөн хүрээтэйгээр тал бүрээс нь судалж өөрсдийн үзэл бодлын үүднээс өөр хоорондоо илт зөрүүтэй биш олон янзын тодорхойлолт гаргасан байдаг бөгөөд эдгээр тодорхойлолтыг нэгтгэн дүгнэж үзвэл гамшиг нь аюул, ослоос учирсан хохирол ба түүнд нэрвэгдэгсдийн хор уршгийг арилгахад тухайн нийгмийн чадавхаас хэтэрсэн /тухайн газар орны чадавх хүрэхгүй болсон нөхцөл/ үзэгдэл тохиолдох гэсэн утгаар гол төлөв тодорхойлогдож байна

Дэлхий нийтэд PPP (Public Private Partnership) хэмээх гуравхан үсгээр товчлогдон хэрэглэгдэх болсон Төр, хувийн хэвшлийн түншлэлийн санаачилгын гол утга агуулга нь чухамдаа төрөөс нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа хувийн хэвшил болон төрийн бус байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэхэд байдаг. Төр хувийн хэвшилтэй хөрөнгө санхүү, ур чадвараа нэгтгэснээр эрсдэл болон үр дүнгээ хуваалцаж бэрхшээл сорилтыг гарз хохирол багатай даван туулах шинэ гарц бий болгож байгаа нь аливаа салбарт ялангуяа гамшгийн эрсдэлийг бууруулахад онцгой ач холбогдолтой юм.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлсэн туршлага, судалгаанаас үзэхэд энэхүү үйл ажиллагаа нь Засгийн газарт нэлээд олон талын ашиг тусыг авчирдаг байна. Тодруулбал, төсвийн хязгаарлалтын улмаас томоохон төслийг бүрэлдэхүүн хэсгээр задлан авч үзэхийн оронд асуудлыг бүтээлч болон шинэлэг байдлаар шийдэх, төсөл хэрэгжих зардал болон цаг

хугацааг бууруулах. эрсдэлийг шилжүүлэх илүү туршлагатай томоохон худалдан авагчийг татан оролцуулах, шинэ технологи нэвтрүүлэх зэрэг юм.

Гамшгийн эрсдэлийг бууруулах нь маш нарийн зохицуулалт бүхий хөгжлийн хандлагатай олон талт асуудал бөгөөд түүнийг дан ганц гамшгаас хамгаалах салбарт уйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлэх боломжгүй гэдгийг дэлхий нийт хүлээн зөвшөөрч НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөл болон Ерөнхий ассамблейгаас улс орнуудыг гамшгийн эрсдэл бууруулах үндэсний механизмтай болохыг зөвлөж байгаа юм. Энэ зөвлөмжийн хүрээнд гамшгийн эрсдэлийг бууруулахад төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудлыг авч үзэж байна.

НҮБ-аас тодорхойлсон гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлд төр хувийн хэвшлийн түншлэлийн

1. Түншлэлийг сурталчлах, мэдлэгийг нэмэгдүүлэх хэлбэр. Хувийн салбар бусад оролцогч талуудтай түншлэхдээ аливаа асуудлыг шийдэхэд хувь нэмрээ оруулах, уриалах, тэргүүлэн оролцох замаар манлайллын үүргийг гүйцэтгэнэ. Бизнесийн байгууллагууд Засгийн газар ба агентлагуудтай түншилж, эдийн засгийн олон салбаруудаас оролцогчидтой яриа хэлэлцээр хийж, аливаа асуудлыг шийдэх ажиллагааг өргөн зохион байгуулдаг.

2. Нийгэмд хөрөнгө оруулах ба хандив тусламж үзүүлэх түншлэлийн хэлбэр, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, сайн дурынхан эсвэл тусгай шинжээчээр хангах, бараа бүтээгдэхүүнээр буцалтгүй тусламж олгох зэргээр өөрийн дотоод үйл ажиллагаагаараа дамжуулан хувь нэмэр оруулдаг.

3. Үндсэн үйл ажиллагааныхаа хүрээнд түншлэх хэлбэр, ажлын байр нэмэгдүүлэх, харилцан ашигтай хөрөнгө оруулалт хийх, эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулах, татварын орлогыг нэмэгдүүлэх, нийгэм, байгаль орчны эсвэл ёс зүйн стандартыг хэрэгжүүлэх болон нэн шаардлагатай бараа, үйлчилгээгээр хангах зэргээр түншүүд хамтран ажиллаж болно гэсэн гурван хэлбэрийг тодорхойлсон байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулахад төр хувийн хэвлийн түншлэх боломжийг судалсны үндсэн дээр дараах саналуудыг дэвшүүлж байна.

- Гамшгийн эрсдэлийг бууруулахад төр хувийн хэвшлийн түншлэлийн талаар орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагууд ойлголт хангалтгүй байгаа тул түншлэлийг хэрэгжүүлсэн гадаад улс орны туршлагыг сурталчлах, аж ахуйн нэгж, байгууллагууд гамшгийн эрсдэлийг бууруулахад ямар хэлбэрээр түншлэх боломжийг бүрдүүлэх, хөтөлбөр боловсруулах, зөвлөгөө мэдээллээр хангах.

- Онцгой байдлын байгууллага нь аж ахуйн нэгж, байгууллагуудтай гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр түншлэх аргачлалтай болох. Энэ аргачлал дээрээ тулгуурлан мэргэжлийн боловсон хүчнийг энэ салбарт ажиллуулах нь чухал гэдгийг эрх бүхний хүмүүст ойлгуулах.

Гамшгийн эрсдэлийг бууруулах түншлэлийн арга хэлбэрийг аж ахуйн нэгж, байгууллагуудад хэрэгжүүлэх чадварлаг ажилтнуудыг бэлтгэх,

- мэргэжлийн түншлэл, хамтын ажиллагаа хариуцсан ажилтнуудыг баталгаат ажлын байраар хангах, юуны өмнө түншлэлийг зохион байгуулах. ур чадвар эзэмшүүлэх. ажлын байрны аюулгүй байдлыг бий болгох, тэднийг хамгаалах хууль эрх зүйн орчинг бий болгох.

- Түншлэлийн шинэлэг хэлбэрийг бий болгох, аж ахуйн нэгж, байгууллагуудын түншлэх түвшинг тогтоохдоо орлогоор нь биш. хэрэглээгээр нь тооцдогоор шийдвэрлэх. эрх зүйн хувьд баталгаажуулах, амьдралд бодитойгоор хэрэгжүүлэх. Үүний тулд түншлэх аргачлалыг маш сайн хийж, түншлэх боломжийг зөв тодорхойлох хэрэгтэй.

Дээрх саналуудыг хэрэгжүүлснээр орон нутагт гамшгийн эрсдэлийг бууруулахад төр. хувийн хэвшлийн түншлэх ялангуяа аж ахуйн нэгж, байгууллагуудтай түншлэх боломжтой хэмээн үзэж байна. Иймд төрийн нуруунаас бага ч болов ачааг хөнгөлөх зорилгоор гамшгийн эрсдэлийг бууруулахад аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоо, түншлэх боломжийг бүрдүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.